



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 498

Улаанбаатар хот

### Хөрөнгө акталж сэлбэгээр худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 33,071,980.00 (гучин гурван сая далан нэгэн мянга есөн зуун наян) төгрөгийн балансын үнэ, 28,794,894.56 (хорин найман сая долоон зуун ерэн дөрвөн мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, сэлбэгээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Сэлбэгээр худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Акталж, данснаас хассан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б. ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

13201921

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн  
498 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, СЭЛБЭГЭЭР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуриимлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Сэлбэгээр худалдах доод үнэ
				(Төгрөг)		
1	Хино кран, 62-38 APA, GD3HKA10064	1990/2007	33,071,980.00	28,794,894.56	4,277,085.44	1,100,000.00
Нийт дүн			33,071,980.00	28,794,894.56	4,277,085.44	1,100,000.00
			(гучин гурван сая далан нэгэн мянга есөн зуун наян)	(хорин найман сая долоон зуун ерэн дөрвөн мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг тавин зургаан мөнгө)	(дөрвөн сая хоёр зуун далан долоон мянга наян таван төгрөг дөчин дөрвөн мөнгө)	(нэг сая нэг зуун мянган)